*Санхүүгийн зохицуулах хорооны 2021 оны 6 дугаар сарын*
*11-ний өдрийн 255 дугаар тогтоолоор баталсан*
*"Үнэт цаасны бүртгэлийн журам"-ын 4 дүгээр хавсралт*
*"Үнэт цаас гаргагчийн хугацаат тайлагнал болон тухай бүр*
*мэдээлэх мэдээллийн агуулга, хэлбэр"-ийн Жилийн*
*үйл ажиллагааны тайлагнал маягт 1*

| **Жилийн үйл ажиллагааны тайлан /маягт 1/** | |
|---|---|
| ***Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 20 дугаар зүйлд Үнэт цаас гаргагчийн нийтлэг үүргийг хуульчилсан бөгөөд үнэт цаас гаргагч нь жилийн үйл ажиллагааны тайлан дараах маягтын дагуу Санхүүгийн зохицуулах хороо, арилжаа эрхлэх байгууллагад мэдээлэл ирүүлж, өөрийн цахим хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлэл хүргэх үүрэгтэй.*** | |
| | |
| *Тайлагнах хугацаа* | 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс<br>2022 оны 12 дугаар сарын 31-ний өдөр |
| *Үнэт цаас гаргагчийн нэр, улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, үнэт цаасны код, утасны дугаар* | Нэр: Ард Кредит ББСБ ХК<br>УБГД: 9010002003<br>ҮЦК: ADB<br>Утас: +976 77003322 |
| *Бүртгэлтэй арилжаа эрхлэх байгууллагын нэр* | Монголын Хөрөнгийн Бирж |
| *Бизнесийн үйл ажиллагааны салбар* | Банк бус санхүүгийн байгууллага |
| *Жилийн эцсийн санхүүгийн тайланд аудитын дүгнэлт гаргасан СЗХ-нд бүртгэлтэй аудитын компанийн нэр, бүртгүүлсэн огноо* | Грант Торнтон Аудит ХХК |
| *Үнэт цаас гаргагчийн гаргасан нийт хувьцааны тоо ширхэг* | 280,000,000 (хоёр зуун наян сая) ширхэг |
| *Жилийн тайланг бэлтгэсэн мэргэжилтэн, хянасан албан тушаалтны нэр* | **Бэлтгэсэн:**<br>ТУЗНБД Ц.Номинцэцэг<br>СМ Д.Лхагва-Очир<br>**Хянасан:**<br>Гүйцэтгэх захирал: Г.Тэлмэн<br>Зээл эрхэлсэн захирал Б.Баттөгс |
| | |

<table>
<tr><td>1.</td><td colspan="2">Тайлант жилийн санхүүгийн тайлан /хураангуй тайлангийн үзүүлэлтийг бөглөж, санхүүгийн тайланг хавсаргана/</td></tr>
<tr><td></td><td>Санхүүгийн байдлын үзүүлэлт</td><td>
<table>
<tr><th>Үзүүлэлт (мянган төгрөг)</th><th>Эхний үлдэгдэл (1-р сарын 1)</th><th>Эцсийн үлдэгдэл (12-р сарын 31)</th></tr>
<tr><td colspan="3">Хөрөнгө</td></tr>
<tr><td>Эргэлтийн хөрөнгө</td><td>71,574,622</td><td>56,447,149</td></tr>
<tr><td>Эргэлтийн бус хөрөнгө</td><td>1,813,129</td><td>1,591,599</td></tr>
<tr><td>Нийт хөрөнгө</td><td>73,387,751</td><td>58,038,748</td></tr>
<tr><td colspan="3">Өр төлбөр ба эздийн өмч</td></tr>
<tr><td>Өр төлбөрийн нийт дүн</td><td>50,782,486</td><td>39,989,326</td></tr>
<tr><td>Эздийн өмч</td><td>22,605,265</td><td>18,049,422</td></tr>
<tr><td>Нийт өр төлбөр ба эздийн өмч</td><td>73,387,751</td><td>58,038,748</td></tr>
</table>
</td></tr>
<tr><td></td><td>Орлогын тайлан</td><td>
<table>
<tr><th>Үзүүлэлт (мянган төгрөг)</th><th>Өмнөх оны дүн</th><th>Тайлант оны дүн</th></tr>
<tr><td>Хүүгийн орлого</td><td>7,768,611</td><td>11,339,294</td></tr>
<tr><td>Хүүгийн зардал</td><td>3,913,870</td><td>6,513,600</td></tr>
<tr><td>Цэвэр хүүгийн орлого</td><td>3,854,741</td><td>4,825,694</td></tr>
<tr><td>Хүүгийн бус орлого</td><td>7,588,882</td><td>5,945,035</td></tr>
<tr><td>Хүүгийн бус зардал</td><td>5,136,329</td><td>6,335,565</td></tr>
<tr><td>Болзошгүй эрсдэлийн зардал</td><td>2,145,842</td><td>2,530,969</td></tr>
<tr><td>Үндсэн бус үйл ажиллагааны орлого</td><td>678,569</td><td>575,759</td></tr>
<tr><td>Үндсэн бус үйл ажиллагааны зардал</td><td>292,033</td><td>45,389</td></tr>
<tr><td>Татварын өмнөх ашиг</td><td>4,547,988</td><td>2,434,565</td></tr>
<tr><td>Орлогын татварын зардал</td><td>623,171</td><td>375,341</td></tr>
<tr><td>Цэвэр ашиг</td><td>3,924,817</td><td>2,059,224</td></tr>
</table>
</td></tr>
<tr><td></td><td colspan="2">Өмчийн өөрчлөлтийн тайлан Мөнгөн хөрөнгийн тайланг Хавсралт 3, 4-с харна уу.</td></tr>
<tr><td>1.1.</td><td colspan="2">Жилийн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлт</td></tr>
<tr><td></td><td colspan="2">Аудитын компаниас зэрэг дүгнэлт өгсөн</td></tr>
</table>

| | |
|---|---|
| *1.2.* | *Аудитын тодорхойлох захидал /тодорхойлох захидлыг энэхүү зааварт дурдсан агуулгын хүрээнд боловсруулсан байх/* |

Grant Thornton

**"ГРАНТ ТОРНТОН АУДИТ" ХХК**
**Аудит, татвар, зөвлөх үйлчилгээний**
**дэлхийн сүлжээний бие даасан фирм**


Далай тауэр 9 давхар, ЮНЕСКО гудамж, Сүхбаатар дүүрэг, 1 р хороо, Улаанбаатар 14230, Монгол улс
T + 976 70 110744
+ 976 70 110799

Dalai Tower, 9 fl, UNESCO street, Sukhbaatar District-1, Ulaanbaatar 14230, Mongolia
T + 976 70 110744
+ 976 70 110799


# Хураангуй санхүүгийн тайлангийн талаарх Хараат бус аудиторын дүгнэлт

**"Ард кредит ББСБ" ХК-ийн хувьцаа эзэмшигчдэд:**

*Дүгнэлт*

Бид "Ард кредит ББСБ" ХК (цаашид "ББСБ" гэх)-ийн 2022 оны 12 дугаар сарын 31-нээрх санхүүгийн байдал, уг өдрөөр дуусгавар болсон жилийн санхүүгийн үр дүн тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайланг (цаашид "хураангуй санхүүгийн тайлан" гэх) 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон аудитын тайлангаас хураангуйлан авч бэлтгэсэн болно.

Бидний дүгнэлтээр, энэхүү хураангуй санхүүгийн тайлан нь бүх материаллаг зүйлсийн хувьд Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн Санхүүгийн зохицуулах хорооноос батлан гаргасан "Банк бус санхүүгийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийг хөтлөх үлгэрчилсэн заавар"-ын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлэгдсэн байна.

*Хураангуй санхүүгийн тайлан*

Энэхүү хураангуй санхүүгийн тайлан нь Санхүүгийн тайлагналын олон улсын стандартаар шаардсан бүх тодруулгыг иж бүрэн агуулаагүй тул "Ард Кредит ББСБ" ХК-ийн аудитын тайланг бүрэн дүүрэн орлохгүй болно.

Энэхүү хураангуй санхүүгийн тайланд 2023 оны 03 дугаар сарын 30-ны өдрийн манай аудитын тайлангийн дүгнэлттэй ижил дүгнэлт илэрхийлсэн бөгөөд эдгээр санхүүгийн тайлан болон хураангуй санхүүгийн тайланд аудитын тайлангийн өдрөөс хойш балансын дараах үйл явдлын нөлөөллийг тусгаагүй.

*Аудитлагдсан санхүүгийн тайлан ба түүнд өгсөн бидний дүгнэлт*

Бид аудитлагдсан санхүүгийн тайланд зөрөг дүгнэлт өгсөн.

*Удирдлага болон Засаглах эрх мэдэл бүхий этгээдүүдийн Санхүүгийн тайланд хүлээх үүрэг хариуцлага*

ББСБ-ын удирдлага эдгээр санхүүгийн тайлангуудыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн Санхүүгийн зохицуулах хорооноос батлан гаргасан "Банк бус санхүүгийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийг хөтлөх үлгэрчилсэн заавар"-ын дагуу бэлтгэх, үнэн зөв толилуулах үүрэгтэй.

*Аудиторын үүрэг хариуцлага*

Бидний үүрэг хариуцлага бол Аудитын олон улсын стандарт, Монгол улсын Аудитын тухай хуулийн дагуу хийсэн аудитад үндэслэн энэхүү санхүүгийн тайлангуудын талаар хараат бус дүгнэлт өгөх явдал юм.

**Б. ӨСӨРГАРАВ**
**УДИРДАХ ПАРТНЕР**
Монгол улс, Улаанбаатар хот
2023 оны 03 дугаар сарын 30

www.grantthornton.mn

| | | |
|---|---|---|
| 2 | *Үнэт цаас гаргагч нь тайлант хугацаанд санхүүгийн нөхцөл байдал, үйл ажиллагааны үр дүнд нөлөөлсөн хүчин зүйлс, уридлагаас өгсөн үнэлгээ, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар товч тайлбарласан тайлан мэдээлэл* | |
| *2.1.* | *Үйл ажиллагааны үр дүн /санхүүгийн харьцааны үзүүлэлтүүд/* | Үйл ажиллагааны ашгийн хувь: 14.0%<br>Цэвэр ашгийн хувь: 12.1%<br>Өөрийн хөрөнгийн өгөөж: 10.1%<br>Нийт хөрөнгийн өгөөж: 3.1% |
| *2.2.* | *Хөрвөх чадвар болон санхүүгийн нөөц, боломжийн үзүүлэлт* | Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа 12.7%<br>Өр болон өөрийн хөрөнгийн харьцаа (D/E) 1.8 |
| *2.3.* | *Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд гадаад, дотоод орчноос үзүүлж буй нөлөөлөл, үйл ажиллагаа явуулж буй салбарт эзлэх хувь, бүтээгдэхүүн, үйлчилгээний нэр төрөлд гарч буй өөрчлөлт, хөгжил дээрх өөрчлөлтөд үнэт цаас гаргагчийн зүгээс авч хэрэгжүүлэхээр төлөвлөж буй арга хэмжээний мэдээлэл* | 1. Ард Апп Дан системийг нэвтрүүлэв.<br><br>2. Нийлүүлэлтийн гинжин хэлхээний СКОПА төслийг хамтран хэрэгжүүлж, төслийн хүрээнд малын тэжээлийн зээл, мерчантын зээлийн үйлчилгээг шинээр нэвтрүүлэв.<br>3. Pick n Pay /BNPL/ худалдан авалтын зээлийн үйлчилгээг нэвтрүүлэв.<br>4. Гүйлгээ бүрээс хуримтлал үүсгэх “CupCake”-“Хариултаа хадгал” хуримтлалын үйлчилгээг Ард Аппад нэвтрүүлэв.<br><br>5. ББСБ-уудаас анх удаа карт гаргагчийн зөвшөөрөл авав. |
| *2.4.* | *Санхүүгийн байдлын тайлангийн гадуур бүртгэсэн ажил, гүйлгээний талаарх дэлгэрэнгүй мэдээлэл, нягтлан бодох бүртгэлийн бодлогын мэдээлэл /off balance/* | Зээлийн эрсдэлийн сангаас хаасан зээл 3.3 тэрбум төгрөг, хуримтлуулж тооцохыг зогсоосон зээлийн хүү 3.2 тэрбум төгрөг байна. |
| *2.5.* | *Тайлан хугацаанд авсан зээлийн эргэн төлөлт болон зээлийн барьцаа, баталгааны талаарх мэдээлэл;* | Тайлант хугацаанд 89,748 сая төгрөгийн үндсэн зээлийн төлөлт хийлгэв. |

<table>
<tr><td>3.</td><td>Үнэт цаас гаргагчийн тайлант хугацаанд хийгдсэн сонирхлын зөрчилтэй болон их хэмжээний хэлцлийн мэдээлэл, хэлцэл хийх ач холбогдол зорилго, сонирхлын зөрчилтэй этгээдийн талаарх мэдээлэл /тайлан хугацаанд хийгдсэн нийт сонирхлын зөрчилтэй хэлцлийн талаарх мэдээллийг тусгана/</td></tr>
<tr><td></td><td>Тайлант хугацаанд хийгдсэн сонирхлын зөрчилтэй болон их хэмжээний хэлцлийн мэдээллийг хөндлөнгийн аудитын “Холбоотой талууд” хэсэгт тогтмол нийтэд мэдээлдэг болно.</td></tr>
<tr><td>4.</td><td>Цалин урамшууллын мэдээлэл</td></tr>
<tr><td></td><td>2022 онд Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүдийн цалинд 93.6 сая төгрөг, ТУЗ-ийн хурлын бэлтгэл ажил болон бусад зардалд 1.4 сая төгрөг зарцуулсан байна.<br>Урамшууллын бодлого:<br>Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдэд урамшуулал олгохдоо тухайн жилийн ажлын гүйцэтгэл 50%, хурлын ирц 50%-иар тооцож жилд нэг удаа урамшуулал олгодог.</td></tr>
<tr><td>5.</td><td>Компанийн засаглалтай холбоотой мэдээлэл</td></tr>
<tr><td></td><td>Засаглалын бүтэц, үйл ажиллагаа<br>Ард Кредит ББСБ ХК-ийн эрх барих дээд байгууллага нь Хувьцаа эзэмшигчдийн хурал байх бөгөөд түүний чөлөөт цагт компанийн үйл ажиллагааг Хувьцаа эзэмшигчдийн хурлаас томилогдсон Төлөөлөн Удирдах Зөвлөл удирдана.<br>Ард Кредит ББСБ ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөл нь 6 ердийн гишүүн 3 хараат бус гишүүний бүрэлдэхүүнтэй сонгогдсон ба Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс компанийн Гүйцэтгэх захирал, Төлөөлөн Удирдах Зөвлөлийн нарийн бичгийн дарга, Дотоод аудиторыг тус тус томилон ажиллаж байна. Гүйцэтгэх захирал нь компанийн удирдлагын чиг үүрэг, өдөр дутмын үйл ажиллагаанд хяналт тавих, ТУЗ-өөс өгсөн үүрэг даалгаврын биелэлт, стратеги төлөвлөгөөний хэрэгжилтийг ханган ажилладаг.<br>Компанийн бүтэц 2022 онд<br>
</td></tr>
</table>

**Хувьцаа эзэмшигчдийн хурал**

Компанийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2022 оны 4 сарын 30-ны өдөр 11 цаг 30 минутанд Хан-Уул дүүрэг 15-р хороо, Махатма Ганди гудамж-39, Улаанбаатар хот Корпорэйт зочид буудал, Конвешн Центрт зохион байгуулагдав. Хурлаас гарсан шийдвэрийг танилцуулвал:

1. Компанийн жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг батлав;
2. Ард Кредит ББСБ ХК-ийн хаягийг өөрчлөн компанийн дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулан батлав;
3. Давуу эрхийн хувьцаа гаргахыг зөвшөөрөв;
4. Хоёрдогч өглөг гаргахыг зөвшөөрөв.

**Төлөөлөн Удирдах Зөвлөл**

**Ердийн гишүүд:**



**Ч.ГАНЗОРИГ**
Ард Кредит ББСБ ХК-ийн ТУЗ-ийн дарга
Бизнесийн удирдлага мэргэжилтэй
Ай Дакс ХХК-ийн Гүйцэтгэх захирал,
Ард Кредит ББСБ ХК-ийн 0.22%-ийн хувьцаа эзэмшдэг



**О.ОДБАЯР**
Багш, эрх зүйч мэргэжилтэй
Ард Даатгал ХК-ийн ТУЗ-ийн дарга
Ард Кредит ББСБ ХК-ийн 9.75%-ийн хувьцаа эзэмшдэг



**Б.ГАНБАТ**
Санхүү, эдийн засагч мэргэжилтэй
Ард Кредит ББСБ ХК-ийн ТУЗ-ийн гишүүн
Ард Кредит ББСБ ХК-ийн 7,941 ширхэг хувьцаа эзэмшдэг



**Г.УЯНГА**
Банк, санхүүч мэргэжилтэй
Ард Пропертиз ХХК-ийн Гүйцэтгэх захирал
Ард Кредит ББСБ ХК-ийн 0.05%-ийн хувьцаа эзэмшдэг



**Г.ТЭЛМЭН**
ОУЭЗасагч мэргэжилтэй
Ард Кредит ББСБ ХК-ийн Гүйцэтгэх захирал
Ард Кредит ББСБ ХК-ийн 0.08%-ийн хувьцаа эзэмшдэг



**Б.ЗОЛБОО**
ОУНББ, АССА, Эдийн засагч мэргэжилтэй
Ард Санхүүгийн Нэгдэл ХК-ийн Санхүү эрхэлсэн захирал
Ард Кредит ББСБ ХК-ийн 0.08%-ийн хувьцаа эзэмшдэг

**Хараат бус гишүүд:**



**В.ГАНЗОРИГ**
Мэргэшсэн нягтлан бодогч мэргэжилтэй, MBA
CEO клубын ерөнхийлөгч
Бат Солюшн Партнерс ХХК-ийн ТУЗ-ийн дарга
Ард Кредит ББСБ ХК-ийн 0.03%-ийн хувьцаа эзэмшдэг



**Б.СОЛОНГО**
Нягтлан бодогч, Аудитор, мэргэжилтэй
Софтлайн Азия ХХК-ийн Гүйцэтгэх захирал
Оньс Рүүм-н үүсгэн байгуулагч Триквест ХХК-ийн Гүйцэтгэх захирал
Ард Кредит ББСБ ХК-ийн 2,891 ширхэг хувьцаа эзэмшдэг



**С.ЭНХЧИМЭГ**
Бизнесийн удирдлага мэргэжилтэй
Бипрос Монголиа ХХК-ийн үүсгэн байгуулагч
Ард Кредит ББСБ ХК-ийн хувьцаа эзэмшдэггүй

**Гүйцэтгэх удирдлагын баг**



**Г.ТЭЛМЭН**
Гүйцэтгэх захирал



**Х.БИЛГҮҮН**
Санхүү эрхэлсэн захирал



**М.НОМИН-ЭРДЭНЭ**
Бизнес хөгжил, үйл ажиллагаа эрхэлсэн захирал



**Б.БАТТӨГС**
Зээл эрхэлсэн захирал

| | |
|---|---|
| *6.* | *Зах зээлийн эрсдэлийн мэдээлэл* |
| | Ард Кредит ББСБ ХК-ийн хувьцаа эзэмшигч, хөрөнгө оруулагч, бусад оролцогч талууд нь бидний бизнест үүсэх эрсдэлд шууд болон шууд бусаар өртөх боломжтой байдаг тул бидний зүгээс хариуцлагын хүрээнд эрсдэлийн удирдлагын тогтолцоог алба, нэгж бүртээ бүрдүүлэн ажиллаж ирсэн. Байгууллагын дотоод соёл, уур амьсгал нь нийт ажиллагсдын зан төлөв хандлагыг төлөвшүүлдэг. Энэ нь ажиллагсад эрсдэлд хэрхэн хандах, ямар хэмжээний эрсдэл |

хүлээн зөвшөөрөх, эрсдэлийг хэрхэн удирдах зэрэгтэй шууд хамааралтай. Тиймээс бид байгууллагын соёлдоо ажилтан нэг бүр эрсдэлийн удирдлагад хариуцлагатай хандаж, өөрсдийн ажлын дээрх эрсдэл нэг бүрийг тооцоолон ажиллах хэв маягийг бүрдүүлж ажиллаж байна.

Бид тулгарч болзошгүй эрсдэлүүдийг макро эдийн засаг, бодлогын хүүгийн өөрчлөлт, зээлжих зэрэглэл болон зээлийн үйл ажиллагаа, хууль эрх зүйн орчин, тусгай зөвшөөрлийн хүрээнд Санхүүгийн зохицуулах хорооны шаардлага, Монголбанкны бодлогын хүрээ, мэдээллийн аюулгүй байдал, кибер халдлага, бизнесийн салбарын орчин, санхүүгийн эх үүсвэр татан төвлөрүүлэхэд үүсэж болзошгүй эрсдэл зэргээр эрсдэлийн үнэлгээг хийж эрсдэлээс урьдчилан сэргийлэх, эрсдэлийг арилгах, багасгах арга хэмжээнүүдийг шат дараалалтайгаар авч хэрэгжүүлж байна.

Компанийн эрсдэлийн удирдлагын бодлогын хүрээнд ТУЗ ба ТУЗ-ийн дэргэдэх хороод нь өөрсдийн чиг үүрэгт хамаарах асуудлаар эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлдэг. Үүнд:

1. Дотоод аудитын хороо;
2. Санхүү, зээл, эрсдэлийн хороо;
3. Засаглал, нэр дэвшүүлэх, цалин урамшууллын хороо.

ТУЗ-өөс Эрсдэлийн удирдлагын бодлогыг тодорхойлж, эрсдэлийн удирдлагын хэрэгжүүлэлтийн төлөвлөгөөг баталж, эрсдэлийн хүлээн зөвшөөрөх түвшинг тодорхойлох ба хэрэгжилтэд хяналт тавина. ТУЗ-ийн дэргэдэх хороод нь өөрсдийн чиг үүрэгт хамаарах асуудлаар эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлж гүйцэтгэх удирдлагад хяналт тавьж ажиллаж байна.

7. *Хувьцаа эзэмшигчдийн өмчлөлийн мэдээлэл /5 ба түүнээс дээш хувьцаа эзэмшигчдийн нэрс эзэмшлийн хувь, нийт хувьцаа эзэмшигчдийн тоо/*




| Хувьцаа эзэмшигчийн нэр | 2022 | Хувь эзэмшлийн хэмжээ |
|---|---|---|
| Ард Санхүүгийн Нэгдэл ХК | 113,660,996 | 40.59% |
| С.Гэрэлтуяа | 27,305,402 | 9.75% |
| Ардын Тэтгэврийн данс ХХК | 16,232,767 | 5.80% |
| Х.Батхишиг | 14,426,999 | 5.15% |
| С.Оргил | 11,658,223 | 4.16% |
| Г.Бат-Эрдэнэ | 11,648,223 | 4.16% |
| Ард Бит ХХК | 11,217,378 | 4.01% |
| Н.Мөнхнасан | 7,058,824 | 2.52% |
| И Ай Ти ХХК | 6,923,259 | 2.47% |
| А.Сүхдорж | 5,086,580 | 1.82% |
| ТОП 10 хувьцаа эзэмшигчид | 225,218,651 | 80.44% |
| Бусад хувьцаа эзэмшигч | 54,781,349 | 19.56% |
| Хувьцаа эзэмшигчдийн тоо | 13,539 | |

Ард Кредит ББСБ ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн тоо 13,539-д хүрч олон нийтэд нээлттэй хувьцаат компани болсноос хойш жил бүр Монголын Хөрөнгийн Биржийн ТОП-20 индекс болон I ангилалд багтаж ирсэн уламжлалт амжилтаа хадгаллаа. 2022 оны туршид 1.3 тэрбум төгрөгийн 10.0 сая ширхэг компанийн хувьцаа Монголын хөрөнгийн биржээр арилжаалагджээ.

<table>
<tr><td>8.</td><td>Үнэт цаас гаргагч нь төсөл хэрэгжүүлэх зорилгоор нийтэд санал болгон хувьцаа гаргасан бол төсөл хэрэгжиж эхэлснээс хойш дуусах хүртэл хугацаанд төслийн хэрэгжилтийн явц болон татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалтын тайлан мэдээлэл</td></tr>
<tr><td></td><td>Төсөл хэрэгжүүлэх зорилгоор олон нийтэд хувьцаа санал болгоогүй болно.</td></tr>
<tr><td>9.</td><td>Ногдол ашгийн мэдээлэл</td></tr>
<tr><td></td><td>


Ард Кредит ББСБ ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2022 оны 02 сарын 18-ны өдрийн 2022/04 тоот тогтоолоор компанийн 2021 оны жилийн эцсийн цэвэр ашгаас хувьцаа эзэмшигчдэдээ нэгж хувьцаанд 4.5 (дөрөв аравны тав) төгрөг буюу цэвэр ашгийн дүнгээс 1.26 тэрбум төгрөгийн ногдол ашиг тараахаар шийдвэрлэсэн.<br>
Ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2022 оны 4 сарын 8-ны өдрөөр тогтоосон ба 2022 оны 7 сарын 1-ний өдөр Санхүүгийн Зохицуулах Хорооны өгсөн зөвлөмжийн дагуу Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн дансанд шилжүүлсэн.
</td></tr>
<tr><td>10.</td><td>Үнэт цаас гаргагчаас тайлант хугацаанд нийгмийн хариуцлагын чиглэлээр хийгдсэн ажлын тайлангийн мэдээлэл</td></tr>
<tr><td></td><td>Хөрөнгө Оруулагч Үндэстэн, Хувьцаа Эзэмшигчдийн хуралд хүрэлцэн ирсэн 573 хүүхдэд компанийнхаа 10 ширхэг хувьцааг бэлэглэж, 2022 оны 6 сарын 1-ний өдөр Хүүхдийн баяраар Хүүхдийн ертөнц 2022, Momento 1,000 ээжийн арга хэмжээг ивээн тэтгэж, хамтран ажиллав. #БидИлүүБайжЧадна аяныг хамтран хэрэгжүүлж аяны хүрээнд Ардын бүрэлдэхүүн компаниудын ажиллагсдын 1,309 хүүхдэд 10 ширхэг Ард Санхүүгийн Нэгдэл ХК (MSE:AARD)-ийн 5 ширхэг хувьцааг олгож, Монгол Улсын нийт хүүхдүүдэд 3 ширхэг хувьцаа олгох хөдөлгөөнийг эхлүүлэв. Мөн Ард Кредит ББСБ ХК (MSE:ADB)-ийн хувьцаа эзэмшигчдийн хүүхдүүдэд АрдКойн урамшууллаар олгов.</td></tr>
<tr><td colspan="2">Мэдээлэл гаргагч этгээд болон мэдээллийн үнэн зөвийг баталсан этгээдийн гарын үсэг, огноо:</td></tr>
<tr><td>Гүйцэтгэх захирал Г.Тэлмэн<br>/........................................./<br>АРД КРЕДИТ ББСБ ХК</td><td>Зээл эрхэлсэн захирал Б.Баттөгс<br>/................................../</td></tr>
<tr><td colspan="2">Мэдээлэл бэлтгэж, хүргүүлсэн этгээдийн гарын үсэг, огноо: 3/31/2023</td></tr>
<tr><td colspan="2">Овог, нэр: Ц.Номинцэцэг<br>Албан тушаал: ТУЗНБД<br>Гарын үсэг:</td></tr>
</table>

АРД КРЕДИТ ББСБ ХК
1119281372
УЛААНБААТАР ХОТ

*Хавсралт 1*

Grant Thornton

# Санхүүгийн байдлын тайлан

| Мянган төгрөгөөр | 2022 оны 12 сарын 31-ний үлдэгдэл | 2021 оны 12 сарын 31-ний үлдэгдэл |
|---|---|---|
| **Хөрөнгө** | | |
| **Эргэлтийн хөрөнгө** | | |
| Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө | 5,027,668 | 6,956,116 |
| Богино хугацаат хөрөнгө оруулалт | 789,329 | 2,997,377 |
| Зээл | 40,038,098 | 34,177,792 |
| Бусад санхүүгийн хөрөнгө | 2,855,132 | 4,838,475 |
| Бусад эргэлтийн хөрөнгө | 7,736,922 | 22,604,862 |
| **Эргэлтийн хөрөнгийн дүн** | **56,447,149** | **71,574,622** |
| **Эргэлтийн бус хөрөнгө** | | |
| Үндсэн хөрөнгө, цэвэр | 938,892.00 | 541,511 |
| Биет бус хөрөнгө, цэвэр | 652,707 | 625,738 |
| Ашиглах эрхтэй хөрөнгө | - | 645,880 |
| **Эргэлтийн бус хөрөнгийн дүн** | **1,591,599** | **1,813,129** |
| **Нийт хөрөнгө** | **58,038,748** | **73,387,751** |
| | | |
| **Өр төлбөр ба эздийн өмч** | | |
| Банк, санхүүгийн байгууллагаас зээл | 11,211,776 | 19,983,388 |
| Өрийн бичгээрх өглөг | 6,886,000 | 561,000 |
| Хойшлогдсон татварын өр төлбөр | 117,509 | 824,119 |
| Бусад эх үүсвэр | 13,641,277 | 18,189,153 |
| Бусад өр төлбөр | 8,132,764 | 11,224,826 |
| **Өр төлбөрийн нийт дүн** | **39,989,326** | **50,782,486** |
| **Эздийн өмч** | | |
| Хувьцаат капитал | 2,800,000 | 2,800,000 |
| Халаасны хувьцаа | (58) | - |
| Нэмж төлөгдсөн капитал | 5,352,792 | 5,342,623 |
| Бусад өмч | 1,598,872 | 7,053,406 |
| Хуримтлагдсан ашиг | 8,297,816 | 7,409,236 |
| **Эздийн өмчийн дүн** | **18,049,422** | **22,605,265** |
| **Өр төлбөр ба эздийн өмчийн дүн** | **58,038,748** | **73,387,751** |

Хавсралт 2

59567 СБА2511
ARD
АРД КРЕДИТ ББСБ ХК
1119281372
УЛААНБААТАР

Grant Thornton

# Орлогын дэлгэрэнгүй тайлан

| Мянган төгрөгөөр | 2022 он | 2021 он |
|---|---|---|
| Хүүгийн орлого | 11,339,294 | 7,768,611 |
| Хүүгийн зардал | (6,513,600) | (3,913,870) |
| **Цэвэр хүүгийн орлого** | **4,825,694** | **3,854,741** |
| | | |
| Хүүгийн бус орлого | 5,945,035 | 7,588,882 |
| Хүүгийн бус зардал | (6,335,565) | (5,136,329) |
| **Цэвэр хүүгийн бус орлого** | **(390,530)** | **2,452,553** |
| | | |
| **Болзошгүй эрсдэлийн сан байгуулахаас өмнөх үйл ажиллагааны ашиг** | | |
| Болзошгүй эрсдэлийн зардал | (2,530,969) | (2,145,842) |
| | | |
| **Үндсэн үйл ажиллагааны ашиг** | **1,904,195** | **4,161,452** |
| | | |
| Үндсэн бус үйл ажиллагааны орлого | 575,759 | 678,569 |
| Үндсэн бус үйл ажиллагааны зардал | (45,389) | (292,033) |
| | | |
| **Татвар төлөхийн өмнөх ашиг** | **2,434,565** | **4,547,988** |
| Орлогын албан татварын зардал | (375,341) | (623,171) |
| | | |
| **Цэвэр ашиг** | **2,059,224** | **3,924,817** |
| | | |
| **Бусад дэлгэрэнгүй орлого** | | |
| Бусад дэлгэрэнгүй орлогын нэмэгдэл | (10,365,666) | 6,700,921 |
| | | |
| Нийт дэлгэрэнгүй орлого | **(8,306,442)** | **10,625,738** |
| | | |
| **Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг** | **0.007** | **0.014** |

*Хавсралт 3*

459567 СБА2511
ARD
АРД КРЕДИТ
ББСБ ХК
УЛААНБААТАР

Grant Thornton

# Өмчийн өөрчлөлтийн тайлан

| Мянган төгрөгөөр | Өмч | Халаасны хувьцаа | Нэмж төлөгдсөн капитал | Эздийн өмчийн бусад хэсэг | Хуримтлагд -сан ашиг | Нийт дүн |
|---|---|---|---|---|---|---|
| **2020 оны 12 сарын 31-ний үлдэгдэл** | **2,800,000** | **(64,396)** | **3,694,292** | **976,953** | **3,846,421** | **11,253,270** |
| Тайлант үеийн цэвэр ашиг | - | - | - | - | 3,924,817 | 3,924,817 |
| Бусад дэлгэрэнгүй орлого | - | - | - | 7,053,406 | - | 7,053,406 |
| Өмчид гарсан өөрчлөлт | - | 64,396 | 1,648,331 | - | - | 1,712,727 |
| Ногдол ашиг | - | - | - | - | (986,472) | (986,472) |
| Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн | - | - | - | (976,953) | 624,470 | (352,483) |
| **2021 оны 12 сарын 31-ний үлдэгдэл** | **2,800,000** | **-** | **5,342,623** | **7,053,406** | **7,409,236** | **22,605,265** |
| Тайлант үеийн цэвэр ашиг | - | - | - | - | 2,059,224 | 2,059,224 |
| Бусад дэлгэрэнгүй орлого | - | - | - | (10,365,666) | - | (10,365,666) |
| Өмчид гарсан өөрчлөлт | - | (58) | 10,170 | - | 5,000,000 | 5,010,112 |
| Ногдол ашиг | - | - | - | - | (1,259,514) | (1,259,514) |
| Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн | - | - | - | (88,869) | 88,869 | - |
| **2022 оны 12 сарын 31-ний үлдэгдэл** | **2,800,000** | **(58)** | **5,352,793** | **(3,401,129)** | **13,297,816** | **18,049,422** |

Хавсралт 4

СБА2511
АРД КРЕДИТ ББСБ ХК
1119281372
УЛААНБААТАР ХОТ

Grant Thornton

# Мөнгөн гүйлгээний тайлан

| Мянган төгрөгөөр | 2022 | 2021 |
|---|---|---|
| **Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ** | | |
| **Мөнгөн орлогын дүн** | **130,140,881** | **124,274,280** |
| Харилцагчдад олгосон зээлийн эргэн төлөлт /үндсэн зээл/ | 95,763,020 | 68,006,439 |
| Итгэлцэл, татан төвлөрүүлсэн хөрөнгө | 13,683,046 | 44,428,924 |
| Зээлийн хүүгийн орлого | 11,788,785 | 7,986,407 |
| Үйлчилгээний хураамж, шимтгэлийн орлого | 2,763,557 | 2,924,745 |
| Бусад үйлчилгээний орлого | 6,142,473 | 927,765 |
| **Мөнгөн зарлагын дүн** | **(131,436,190)** | **(129,432,407)** |
| Харилцагчдад олгосон зээлд төлсөн | (94,897,581) | (84,990,850) |
| Итгэлцэл татан төвлөрүүлсэн хөрөнгө төлөлт | (15,643,166) | (36,210,940) |
| Итгэлцлийн үйлчилгээний хүүгийн зардалд төлсөн | (2,647,225) | (1,671,947) |
| Үндсэн ба нэмэгдэл цалинд төлсөн | (795,651) | (759,903) |
| Түрээс, менежментийн зардалд төлсөн | (14,001) | (790,679) |
| Аудитын төлбөр, мэргэжлийн зөвлөгөө үйлчилгээний мөнгө | (1,134,554) | (29,125) |
| Татвар, даатгалд төлсөн | (966,586) | (1,125,260) |
| Бондын хүүгийн зардалд төлсөн | (626,720) | (465,501) |
| Зохицуулалтын үйлчилгээний хураамжид төлсөн мөнгө | (28,657) | (21,940) |
| Нийгмийн даатгалын шимтгэлд төлсөн | (269,029) | (236,552) |
| Шатахуун, холбоо, интернет, сэлбэг хэрэгсэлд төлсөн | (46,258) | (37,969) |
| Банк, санхүүгийн байгууллагаас авсан зээлийн хүүгийн зардалд төлсөн | (2,052,080) | (508,101) |
| Бичиг хэргийн зардал, ариун цэврийн зардалд төлсөн | (25,947) | (32,122) |
| Албан томилолт, сургалтын зардалд төлсөн | (38,894) | (28,545) |
| Ажилтнуудад олгосон нөхөн олговор, тэтгэмжид төлсөн | (4,487) | (2,799) |
| Зар сурталчилгаанд төлсөн мөнгө | (85,517) | - |
| Зээл болон түүнтэй холбоотой авлагыг барагдуулахтай холбогдон гарсан мөнгө | (20,021) | - |
| Бусад үйлчилгээнд төлсөн мөнгө | (12,139,816) | (2,520,174) |
| **Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн** | **(1,295,309)** | **(5,158,127)** |
| **Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ** | | |
| **Мөнгөн орлогын дүн** | **572,317** | **15,183** |
| Харилцах, хадгаламжийн хүүгийн орлого | - | 18 |
| Ногдол ашгийн орлого | 25,103 | 15,165 |
| Бусад мөнгөн орлого | 547,214 | - |
| **Мөнгөн зарлагын дүн** | **(44,949)** | **(75,704)** |
| Хөрөнгө худалдан авахад төлсөн мөнгө | - | (75,704) |
| Баяр ёслол, зочин төлөөлөгчийн зардалд төлсөн мөнгө | (25,262) | - |
| Бусад үйлчилгээнд төлсөн мөнгө | (19,687) | - |
| **Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн** | **527,368** | **(60,521)** |

5459567 СБА2511

*Хавсралт 4*

АРД КРЕДИТ ББСБ ХК
1119281372
УЛААНБААТАР ХОТ

Grant Thornton

# Мөнгөн гүйлгээний тайлан (үргэлжлэл)

| | | |
|---|---|---|
| **Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ** | | |
| **Мөнгөн орлогын дүн** | **14,336,252** | **19,115,413** |
| Бонд гаргалтаас хүлээн авсан мөнгө | 6,886,000 | - |
| Банк, санхүүгийн байгууллагаас авсан зээл | 7,450,252 | 19,115,413 |
| **Мөнгөн зарлагын дүн** | **(15,496,759)** | **(10,190,331)** |
| Банк, санхүүгийн зээлийг төлсөн мөнгө | (13,537,519) | (5,564,414) |
| Бондын төлбөрт төлсөн мөнгө | (561,000) | (3,100,000) |
| Ногдол ашигт төлсөн мөнгө | (1,160,508) | (904,655) |
| Үнэт цаас худалдан авахад төлсөн мөнгө | (237,733) | (621,262) |
| **Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн** | **(1,160,508)** | **8,925,082** |
| **Бүх цэвэр мөнгөн гүйлгээ** | **(1,928,448)** | **3,706,434** |
| **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | 6,956,116 | 3,249,682 |
| **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | 5,027,668 | 6,956,116 |

Тодруулга: Ард кредит ББСБ ХК-ийн энэхүү хураангуй санхүүгийн тайланг Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн эрх бүхий байгууллагын баталсан холбогдох дүрэм, журмын дагуу бэлтгэсэн санхүүгийн байдлын тайлан болон орлогын дэлгэрэнгүй тайлангаас ямар нэгэн зөрүүгүйгээр хураангуйлан бэлтгэсэн болно.